



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/131/СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.dornogovi.audit.mn

Дорноговь аймаг

2020 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 70522734

Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Энхцэцэг

Утас: 70523020

Цахим хаяг: enkhsetseg.e@audit.gov.mn

Аудитор:

Т.Мөнхтогтох

Цахим хаяг: munkhtogtokht@audit.gov.mn

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	9
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.13. Шилэн дансны мэдээлэл.....	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
Менежментийн захидал.....	11
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	13
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	13
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	14
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	16
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	18
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	19
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	21



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

2020.02.18 № 1-6/78
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

010020005

Үүрэг, хариуцлага

Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газар нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2.1. Оршил

Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Дарга М.Мөнхбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 22-аас 2020 оны 02 дугаар сарын 23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн дотор эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Мөнхтогтох хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 1/31 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь Хууль тогтоомж, стандартын хэрэгжилтэд төрийн захиргааны хяналт тавих замаар Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдлоос хамгаалуулах, чанартай ажил, үйлчилгээг хэрэглэх, хөдөлмөрлөх эрхийг хангах, бизнес эрхлэгчдийн таатай орчинг бүрдүүлэхэд оршино.

Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хэрэглэгч бизнес эрхлэгч олон нийтийн хамтын хяналтыг бэхжүүлэх замаар хүний амь нас, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлээс бодитоор урьдчилан сэргийлж эрсдэлийг бууруулна.
- Нээлттэй байдлыг ханган, цахим үйлчилгээг хөгжүүлж хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- Нийт албан хаагчдын мэдлэг, ур чадвар, санаачилга, сахилга хариуцлагыг дээшлүүлж, өөрийгөө өөрчлөх хандлагыг төлөвшүүлнэ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”
- Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”
- Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоол “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”
- Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоол “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам”
- Засгийн газрын 2019 оны 24 дүгээр тогтоол “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2019 оны 277 дугаар тогтоол “Төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг шинэчлэн тогтоох тухай”

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “emerald” программ хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 30 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн Нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 344,880.5 мянган төгрөгөөс тооцон 3,448.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 8,681.5 мянган төгрөгөөр тооцсон нь ажил гүйлгээний цар хүрээ багатай холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 119,874.8 мянган төгрөгөөр буюу 28.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	15,302.2	15,302.2
Авлага	15.4	0.0	-15.4
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	34,317.0	41,718.6	7,401.6
Үндсэн хөрөнгө	382,690.0	479,876.2	97,186.2
Нийт хөрөнгө	417,022.4	536,897.2	119,874.8
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	417,022.4	536,897.2	119,874.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	417,022.4	536,897.2	119,874.8

Авлага дансны үлдэгдэл буурсан байна. Авлага дансны үлдэгдэлд 2018 онд үүссэн 15.4 мянган төгрөгийн байгууллагаас авах авлага байна. Үүнийг 2019 онд барагдуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө 2,547.2 мянган төгрөг, 4,854.5 мянган төгрөгийн хөрөнгө ашиглалтад байгаа хангамжийн материал зэргээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэлд 2012-2019 онд худалдаж авсан 41,718.7 мянган төгрөгийн Бичиг хэргийн болон аж ахуйн, эм боох материал, түлш, шатах тослох зэрэг бараа материал байна.

2019 оны эцэст 7,401.6 мянган төгрөгийн худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгэсэн нь Онцгой нөхцөл байдал үүссэн үед байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулахтай холбоотой шатахуун, тослох материал, эм боох материал, аж ахуйн материал, бичиг хэргийн материал зэрэг байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 27,676.3 мянган төгрөгөөр өссөн бөгөөд үүний 26,196.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг Дорноговь аймгийн Замын-Үүд боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албанаас, 1,480.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораториас үнэ төлбөргүй авсан байна. Мөн үндсэн хөрөнгийг өртөг нэмэгдүүлж, ашиглалтын хугацааг 1-5 жилээр сунгасан зэргээс шалтгаалжээ. Тайлант онд 11,837.9 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хассан байна.

Биет бус хөрөнгө буюу программ хангамжийн үнэ 1,626.0 мянган төгрөгөөр өссөн нь өртөг нэмэгдүүлж, ашиглалтын хугацааг сунгасантай холбоотой.

Өр төлбөр байхгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 536,897.2 мянган төгрөг болж 119,874.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнөөс шалтгаалжээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт гараагүй байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газар нь 2019 онд 89,000.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 70,567.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 79.2 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Ариутгалын орлого	82,000.0	54,709.2	27,290.8	66.7
Лабораторийн орлого	7,000.0	15,858.3	-8,858.3	226.5
Нийт дүн	89,000.0	70,567.5	18,432.5	79.2

Ариутгалын орлого 27,290.8 мянган төгрөгөөр тасарсан нь Ханги хилийн боомтоор тээвэр хийх ачааны автомашины С зөвшөөрлийн тоо буурсан, БНХАУ-ын хил дээр ачаа хүлээн авалт саатдаг, хүлээгдэл үүсэх зэрэг шалтгаанаар орж гарах тээврийн хөдөлгөөний тоо буурснаас шалтгаалсан байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 3 зориулалтад 762,225.3 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 675,965.0 мянган төгрөгийг бараа үйлчилгээний зардалд, 86,260.3 мянган төгрөгийг бусад урсгал шилжүүлэгт зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 762,225.3 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 654,138.9 мянган төгрөг буюу 85.8 хувьтай байгаа нь Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2018 оны А/19 дүгээр тушаалаар нийт 46 орон тоо батлагдсан боловч 2019 онд бүтэн орон тоогоор ажиллаагүй, Ханги мандалын боомтын гэрэл цахилгааны зардал хэмнэгдсэн зэргээс шалтгаалан /цалин хөлс болон нэмэгдэл урамшил 427,315.9 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 51,863.3 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 23,452.7 мянган төгрөг, хангамж бараа материал 29,029.3 мянган төгрөг, нормативт зардал 14,052.1 мянган төгрөг, эд хогшил худалдан авах 8,124.7 мянган төгрөг, томилолт зочны зардал 12,317.4 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 7,268.4 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 474.1 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлэг 80,240.6 мянган төгрөг/ нийт дүнгээр 108,138.5 мянган төгрөг хэмнэгдэж үлдэгдлийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсөв:

Аймгийн Засаг даргын 2019 оны А/568 дугаар захирамжийн дагуу 1,879.6 мянган төгрөгийн дэмжлэгийг аймгийн Онцгой байдлын газраас үзүүлсэн.

Үүнээс “Говийн чоно-2019” гамшгийн хор уршгийг арилгах олон улсын сургалт, дадлага сургууль, туршлага солилцох үйл ажиллагааны үед зохион байгуулагдах “Химийн бодисын ослын үед авах хариу арга хэмжээ” үзүүлэх сургалтын зардал болох нэг удаагийн иж бүрэн хамгаалах хувцас хэрэглэл, маск, малгай, таних тэмдэг, ахуйн материалуудад 1,876.9 мянган төгрөг, компьютер дээрх үзүүлэнг хананд дүрслэн харуулах зориулалттай проектор 1,000.0 мянган төгрөг нийт 2,876.9 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 52.1 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 2 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл тодорхойлж нийт 3 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 146 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 0 мэдээллийг байршуулаагүй байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Нийт 1 зөвлөмж өгснөөс зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1 Орлогын данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Батлагдсан орлогын төлөвлөгөө 18.4 сая төгрөгөөр тасарсан

Энэ нь (Хэмжилт, иж бүрэн байх) батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 41.2 бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ 41.2.1 “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” тус тус зөрчсөн байна.

1.2 Эрсдэл:

Орлогын төлөвлөгөө 18.4 сая төгрөгөөр тасарсан

1.3 Өгсөн зөвлөмж:

Батлагдсан орлогын төлөвлөгөөг биелүүлэх чиглэлээр арга хэмжээ авч ажиллах

2 Зардлын данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

2019 оны цалинг цалингийн программаар бодолгүй excel-ээр бодсон

Энэ нь (Иж бүрэн байх) батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2016 оны А/171 дүгээр тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” 3 дугаар зүйлийн 3.2.14 “цалин хөлсний бүртгэлийг цалингийн системд хөтлөх ба санхүүгийн программ хангамжийг ашиглана” тус тус зөрчсөн байна.

2.2 Эрсдэл:

Цалин хөлс буруу бодогдох.

2.3 Өгсөн зөвлөмж:

Цалинг цалингийн программаар бодож байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	34,332,433.34	57,020,962.72
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	15,302,295.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	15,302,295.00
3121	Төгрөг	0.00	15,302,295.00
31211	Төрийн сангийн харилцах	0.00	15,302,295.00
33	АВЛАГА	15,400.00	0.00
335	Бусад авлага	15,400.00	0.00
3351	Байгууллагаас авах авлага	15,400.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	34,317,033.34	41,718,667.72
351	Түүхий эд материал	8,709,107.60	11,891,826.20
35130	Эм боох материал	8,709,107.60	11,891,826.20
354	Хангамжийн материал	25,607,925.74	29,826,841.52
35410	Бичиг хэргийн материал	2,845,712.77	3,617,664.77
35420	Аж ахуйн материал	20,141,821.97	23,414,785.75
35440	Түлш, шатах тослох материал	1,481,000.00	1,655,000.00
35470	Бусад хангамжийн материал	1,139,391.00	1,139,391.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	382,690,017.58	479,876,282.57
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	382,690,017.58	479,876,282.57
392	Биет хөрөнгө	352,114,017.58	448,616,563.77
39201	Барилга, байгууламж, орон сууц	260,743,585.00	260,743,585.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-8,461,448.25
39203	Авто-тээврийн хэрэгсэл	145,430,100.00	145,430,100.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-110,297,671.14	-117,842,492.35
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	258,616,445.86	391,343,677.51
39206	Хуримтлагдсан элэгдэл	-205,569,363.48	-232,277,803.09
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	31,672,435.30	41,202,178.48
39208	Хуримтлагдсан элэгдэл	-28,481,513.96	-31,521,233.53
393	Биет бус хөрөнгө	30,576,000.00	31,259,718.80
39301	Програм хангамж	913,000.00	1,626,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-913,000.00	-942,281.20
39303	Бусад биет бус хөрөнгө	30,576,000.00	30,576,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	417,022,450.92	536,897,245.29
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	417,022,450.92	536,897,245.29
51	Засгийн газрын хувь оролцоо	417,022,450.92	536,897,245.29
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	267,025,139.22	267,025,139.22
51101	Өмч: - төрийн	267,025,139.22	267,025,139.22
512	Хуримтлагдсан үр дүн	-50,250,255.88	69,624,538.49
51210	Өмнөх үеийн үр дүн	-70,700,465.23	-50,250,255.88
51220	Тайлант үеийн үр дүн	20,450,209.35	119,874,794.37
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	200,247,567.58	200,247,567.58
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	417,022,450.92	536,897,245.29

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	679,337,610.83	988,034,161.39
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	116,966,810.83	222,879,761.39
120	Нийтлэг татварын бус орлого	116,966,810.83	222,879,761.39
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	116,966,810.83	207,577,466.39
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	76,299,610.00	70,567,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	254,399.83	0.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	40,412,801.00	137,009,966.39
120009	Бусад орлого	0.00	15,302,295.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	562,370,800.00	765,154,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	562,370,800.00	765,154,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	560,370,800.00	762,225,300.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,000,000.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	2,879,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	49,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	658,887,401.48	868,159,367.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	658,887,401.48	868,159,367.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	558,688,097.48	609,189,891.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	365,824,313.00	427,315,984.00
210101	Үндсэн цалин	283,727,513.00	328,311,484.00
210102	Нэмэгдэл цалин	45,565,200.00	82,405,500.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,708,000.00	16,599,000.00
210105	Гэрээт ажлын цалин	20,823,600.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,037,206.83	51,863,341.00
210201	Тэтгэврийн даатгал	30,196,723.00	35,387,696.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,075,292.31	4,164,388.00
210203	ҮОМШ өвчний даатгал	2,952,051.52	3,298,231.00
210204	Ажилгүйдлын даатгал	710,285.00	819,367.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,102,855.00	8,193,659.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,982,500.00	23,452,792.00
210301	Гэрэл цахилгаан	4,530,904.00	4,218,209.00
210302	Түлш, халаалт	17,327,796.00	15,955,923.00
210303	Цэвэр, бохир ус	1,265,600.00	1,430,660.00
210304	Байрны түрээс	1,858,200.00	1,848,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	36,836,967.00	30,696,297.00
210401	Бичиг хэрэг	5,227,925.00	6,026,356.00
210402	Тээвэр шатахуун	17,385,000.00	15,266,600.00
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	6,673,946.00	5,723,587.00
210404	Ном, хэвлэл	52,980.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,257,116.00	3,439,754.00
2105	Нормативт зардал	14,131,240.85	11,516,791.40
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	12,787,260.85	8,984,111.40
210502	Хоол, Хүнс	1,343,980.00	2,532,680.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,008,195.00	3,643,840.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	0.00	119,600.00
210604	Урсгал засвар	7,008,195.00	3,524,240.00
2107	Томилот, зочны зардал	14,471,245.00	12,317,400.00

210702	Дотоод албан томилолт	14,471,245.00	12,317,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,164,935.40	6,385,713.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	800,000.00	2,302,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	324,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	859,450.00	1,060,140.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	87,400.00	400,075.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	70,000.00	70,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,181,400.00	1,346,550.00
210807	Газрын төлбөр	49,582.00	15,288.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,817,103.40	866,760.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	44,231,494.40	41,997,732.62
210902	Хичээл үйлвэрлэлийн дадлага хийх	2,822,488.00	474,185.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал	41,409,006.40	41,523,547.62
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	100,199,304.00	258,969,476.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,703,685.00	80,248,056.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,703,685.00	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	78,346,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	1,901,256.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	98,495,619.00	178,721,420.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	98,495,619.00	108,138,520.00
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	70,582,900.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	20,450,209.35	119,874,794.37
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	20,450,209.35	119,874,794.37

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
0	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	638,970,410.00	851,039,595.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	76,599,610.00	85,885,195.00
120	Нийтлэг татварын бус орлого	76,599,610.00	85,885,195.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	76,599,610.00	70,582,900.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	76,599,610.00	70,582,900.00
120009	Бусад орлого	0.00	15,302,295.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	562,370,800.00	765,154,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	560,370,800.00	762,225,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	560,370,800.00	762,225,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,000,000.00	2,929,100.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,000,000.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	2,879,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	49,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	638,970,410.00	835,737,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	615,970,440.00	831,490,300.00
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	515,771,136.00	572,528,224.00
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	365,535,960.00	427,315,984.00
210101	Үндсэн цалин	283,438,160.00	328,311,484.00
210102	Нэмэгдэл	45,566,200.00	82,405,500.00
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	15,708,000.00	16,599,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	20,823,600.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,117,130.00	51,863,341.00
210201	Тэтгэврийн даатгал	30,259,815.00	35,387,696.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,807,616.00	4,164,388.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,869,787.00	3,298,231.00
210204	Ажилгүйдлийн даатгал	742,710.00	819,367.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,437,202.00	8,193,659.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,982,500.00	23,452,792.00
210301	Гэрэл, цахилгаан	4,530,904.00	4,218,209.00
210302	Түлш, халаалт	17,327,796.00	15,955,923.00
210303	Цэвэр, бохир ус	1,265,600.00	1,430,660.00
210304	Байрны түрээс	1,858,200.00	1,848,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,402,761.00	30,906,239.00
210401	Бичиг хэрэг	4,629,040.00	5,744,598.00
210402	Тээвэр, шатахуун	18,789,000.00	15,440,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,673,946.00	5,833,107.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,070,775.00	3,647,934.00
2105	Нормативт зардал	11,066,000.00	14,052,130.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	9,503,820.00	11,815,450.00
210502	Хоол, хүнс	1,562,180.00	2,236,680.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,799,520.00	4,877,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,800,000.00	972,600.00
210604	Урсгал засвар	6,999,520.00	3,905,100.00
2107	Томилот, зочны зардал	14,471,245.00	12,317,400.00

210702	Дотоод албан томилолт	14,471,245.00	12,317,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,421,632.00	7,268,453.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	800,000.00	2,302,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	324,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	859,450.00	1,060,140.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	97,400.00	400,075.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	60,000.00	70,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,569,400.00	1,396,550.00
210807	Газрын төлбөр	49,582.00	15,288.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,685,800.00	1,699,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,974,388.00	474,185.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,974,388.00	474,185.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	100,199,304.00	258,962,076.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,703,685.00	80,240,656.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,703,685.00	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	78,346,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	1,893,856.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	98,495,619.00	178,721,420.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	98,495,619.00	108,138,520.00
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	70,582,900.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	0.00	15,302,295.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	22,999,970.00	4,247,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	22,999,970.00	4,247,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	22,999,970.00	4,247,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	22,999,970.00	4,247,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-22,999,970.00	-4,247,000.00
250001	Гадаад валютын ханшийн зөрүү	0.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	15,302,295.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	15,302,295.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	236,449,139.22	5,054,458.00	-70,700,465.23	170,803,131.99
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	236,449,139.22	5,054,458.00	-70,700,465.23	170,803,131.99
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	195,193,109.58	0.00	195,193,109.58
C05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	30,576,000.00	0.00	0.00	30,576,000.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	20,450,209.35	20,450,209.35
C08	2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	267,025,139.22	200,247,567.58	-50,250,255.88	417,022,450.92
D01	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	267,025,139.22	200,247,567.58	-50,250,255.88	417,022,450.92
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	267,025,139.22	200,247,567.58	-50,250,255.88	417,022,450.92
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	119,874,794.37	119,874,794.37
D09	2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	267,025,139.22	200,247,567.58	69,624,538.49	536,897,245.29

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Тайлант оны			
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	762,225,300.00	654,138,976.00	108,086,324.00	85.8
УРСГАЛ ЗАРДАЛ	762,225,300.00	654,138,976.00	108,086,324.00	85.8
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	675,965,000.00	573,898,320.00	102,066,680.00	84.9
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	510,076,500.00	427,315,984.00	82,760,516.00	83.8
Үндсэн цалин	411,072,000.00	328,311,484.00	82,760,516.00	79.9
Нэмэгдэл цалин	82,405,500.00	82,405,500.00	0.00	100.0
Унаа хоолны Хөнгөлөлт	16,599,000.00	16,599,000.00	0.00	100.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,759,600.00	51,863,341.00	11,896,259.00	81.3
Тэтгэврийн даатгал	43,356,500.00	35,387,696.00	7,968,804.00	81.6
Тэтгэмжийн даатгал	5,100,800.00	4,164,388.00	936,412.00	81.6
ҮОМШӨ-ний даатгал	4,080,600.00	3,298,231.00	782,369.00	80.8
Ажилгүйдлийн даатгал	1,020,200.00	819,367.00	200,833.00	80.3
Эрүүл мэндийн даатгал	10,201,500.00	8,193,659.00	2,007,841.00	80.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,482,500.00	23,452,792.00	6,029,708.00	79.5
Гэрэл, цахилгаан	10,782,500.00	4,218,209.00	6,564,291.00	39.1
Түлш, халаалт	13,604,500.00	15,955,923.00	-2,351,423.00	117.3
Цэвэр, бохир ус	1,295,500.00	1,430,660.00	-135,160.00	110.4
Байрны түрээс	3,800,000.00	1,848,000.00	1,952,000.00	48.6
Хангамж, бараа материалын зардал	29,036,200.00	29,029,335.00	6,865.00	100.0
Бичиг хэрэг	5,463,800.00	5,575,098.00	-111,298.00	102.0
Тээвэр, шатахуун	15,326,600.00	15,326,000.00	600.00	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,742,300.00	5,833,107.00	909,193.00	86.5
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00	0.00	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,263,500.00	2,055,130.00	-791,630.00	162.7
Нормативт зардал	14,066,000.00	14,052,130.00	13,870.00	99.9
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	11,816,000.00	11,815,450.00	550.00	100.0
Хоол, хүнс	2,250,000.00	2,236,680.00	13,320.00	99.4
Эд хогшил, урсгал засварын зардал	8,152,100.00	8,124,700.00	27,400.00	99.7
Багаж, техник, хэрэгсэл	3,247,000.00	3,247,000.00	0.00	100.0
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,000,000.00	972,600.00	27,400.00	97.3
Урсгал засвар	3,905,100.00	3,905,100.00	0.00	100.0
Томилолт, зочны зардал	12,325,000.00	12,317,400.00	7,600.00	99.9
Дотоод албан томилолт	12,325,000.00	12,317,400.00	7,600.00	99.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,589,500.00	7,268,453.00	1,321,047.00	84.6
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,300,000.00	2,302,900.00	997,100.00	69.8

Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	324,000.00	0.00	100.0
Даатгалын үйлчилгээ	1,060,300.00	1,060,140.00	160.00	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	688,200.00	400,075.00	288,125.00	58.1
Тээврийн хэрэгслийн оношилгоо	70,000.00	70,000.00	0.00	100.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,397,000.00	1,396,550.00	450.00	100.0
Газрын төлбөр	50,000.00	15,288.00	34,712.00	30.6
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,700,000.00	1,699,500.00	500.00	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	477,600.00	474,185.00	3,415.00	99.3
Хичээл үйлдвэрлэлийн дадлага	477,600.00	474,185.00	3,415.00	99.3
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	86,260,300.00	80,240,656.00	6,019,644.00	93.0
Бусад урсгал шилжүүлэг	86,260,300.00	80,240,656.00	6,019,644.00	93.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	84,260,300.00	78,346,800.00	5,913,500.00	93.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	1,893,856.00	106,144.00	94.7
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	762,225,300.00	654,086,780.00	108,138,520.00	85.8
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	762,225,300.00	654,086,780.00	108,138,520.00	85.8
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	15,302,295.00	-15,302,295.00	0.0

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	2,929,100.00
УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	2,929,100.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	2,929,100.00
Хангамж, бараа материалын зардал	0.00	1,876,904.00
Бичиг хэрэг	0.00	169,500.00
Тээвэр, шатахуун	0.00	114,600.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	1,592,804.00
Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	1,000,000.00
Багаж, техник, хэрэгсэл	0.00	1,000,000.00
Олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	52,196.00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	52,196.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	2,929,100.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	2,929,100.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	2,879,600.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	49,500.00
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00	0.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00